

**МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ НАУРЫЗ БОЛОН НАРНЫ БАЯРЫН ЗАН ҮЙЛ,
БЭЛГЭДЭЛИЙН СУДАЛГАА
/АСУУЛГА, ЯРИЛЦЛАГЫН АРГААР СУДЛАХ СУДАЛГАА/**

Ц.Цэцэгжаргал (Төв аймгийн музейн Эрдэм шинжилгээний ажилтан)

С.Сувдаа (Төв аймгийн музейн Арга зүйч)

Төв аймгийн Музей анх Төв аймгийн бага хурлын тэргүүлэгчдийн даргын 1951 оны 05-р сарын 04-ны өдрийн 05 тоот шийдвэрээр Орон нутгийг судлах кабинет нэртэй байгуулагдаж /хавсралт -Төв аймгийн архив Ф1, ХН-233, ху 5/ , 1966 оноос ОНС музей болон өргөжиж , 1991 оноос Төв аймгийн музей болсон ба одоо аймгийн Төв музей, 1972 онд Богд хан уулын Манзуширын аманд байгуулагдсан Байгалийн музей, 1992 онд байгуулагдсан шашны Сэрүүн лаврин музей, 1993 онд байгуулагдсан Угсаатны зүйн музей гэсэн салбаруудтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Музейн сан хөмрөг нь 5000 гаруй үзмэртэй. Үүний 8.8 % урлаг, уран сайхан, 46.7% түүхийн, 12.1% угсаатны зүйн, 19.7% шашин, шүтлэгийн, 3.1% археологийн дурсгал, 9.3% байгалийн дурсгал эзэлдэг. Музейн сан хөмрөгөө угсаатны бүлгийн дээл хувцасаар баяжуулах төлөвлөгөөний дагуу сумдаас угсаатны бүлгийн хүн ам зүйн статистик тоон мэдээллийг авч нэгтгэсэн билээ. Энэ удаад 1990 оноос хойших Төв аймагт нүүдэллэн сууршиж буй Казах угсаатны гарал угсаа, нүүдэллэн ирсэн түүхийг, одоогийн амьдарлын хэв маяг болон Наурызын баярын ёс заншилаар дамжуулан Казахстан ард түмний ёс заншил нь уламжлагдан хадгалагдаж байна уу, халх болон бусад угсаатны соёлтой уусан нэгдэж байна уу гэдгийг тодруулах зорилгоор Төв аймгийн Батсүмбэр суманд ажиллахаар төлөвлөсөн.

Батсүмбэр сум байгуулагдсан түүхээс

Төв аймгийн Батсүмбэр сум нь Улаанбаатар хотоос хойт зүгт 79 км, Зуунмод хотоос 120 км зайд оршино. 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын дараа Ардын загийн газраас Монгол улсад шинэчлэлийн олон бодлогыг авч хэрэгжүүлсний нэг нь засаг захиргааны өөрчлөлтүүд юм. 1923 онд Ардын Засгийн газраас “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм”, “Монгол улсын засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм,” “Аймгийг газар усны нэрээр нэрлэсэн тогтоол” зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг батлан гаргасан байна. 1923 оны 10 сарын 19-нд Ардын Засгийн газрын 38-р тогтоолоор аймаг, хошуудын нэг цолыг газар усны нэрээр нэрлэх шийдвэрийн дагуу Түшээт хан аймгийг Богд хан уулын аймаг гэж нэрлэхээр болж анхын даргаар Дархан чин ван Н.Пунцагцэрэн ажиллаж байв.

1923 онд тус аймгийн баатар засгийн хошууг Ноён уулын хошуу, Илдэн засгийн хошууг Хутаг-Өндөр уулын хошуу хэмээн нэрийдэхээр тогтсон. Баатар вангийн хошууны Ноён уул, Тарина, Хужир нуга, Өлгий Шатангаар баясан Ноён номун ханы “Зоотой хувилгааны отгуудаар байгуулсан Их шавийн Загдал ноён уулын отог, Илдэн гүн, Баатар вангийн хошуудын нутаг Чандмань-Бор хужирын отгийн нутаг энд хамрагддаг байсан. Богд хан уулын аймгийн Ноён уулын хошуу Тамгийн газар гэж байсан газарт 1925 онд Хутаг-Өндөр уулын хошууг Ноён уулын хошуутай нийлүүлэн Батсүмбэр уулын хошууг байгуулжээ. 1926 онд Богдхан уулын аймгийн Хутаг-Өндөр, Зүүн бүрэн хан Ноён уулын хошуудад тарж нийлж 1931

Музейн 2018 оны судалгаа

онд Төв аймагбайгуулагдахад Цогт Өндөр нэртэйгээр Ноён уулын хошуунаас байгуулсныг 1956 онд татан буулгаж 1, 2, 5, 6, 7, 8, 9-р багийг Баянчандманьнд, 3, 4-р багийг Зүүнхараад шилжүүлж байгаад 1959 онд Батсүмбэр нэрээр дахин сум байгуулжээ.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1960 оны 10-р сарын 21-ны өдрийн зарлигаар Партизаны нэгдлийг Батсүмбэр САА-тай нийлүүлж, Партизаны нэрэмжит нэгдлийг Батсүмбэр сумын САА-тай нийлүүлж, Партизаны нэрэмжит САА гэж нэрлэх болжээ.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1960 оны 12-р сарын 23-ны өдрийн 256-р зарлигаар Төв аймгийн Цогт-Өндөр сумыг Батсүмбэрийн сангийн аж ахуйтай нэгтгэжээ. Тэр зарлигт “Батсүмбэрийн сум-сангийн аж ахуйд Партизаны нэгдлийг нийлүүлсэнтэй холбогдуулж Цогт-Өндөр сумыг татан буулгаж, Батсүмбэрийн сум-сангийн аж ахуйд одоо байгаа зааг нутгаар нь нэгтгэж ард иргэдий нь уул суманд захируулсугай” гэж заажээ. Сумын төв нь Мандал өртөөтэй нэг дор төвлөрснөөр Батсүмбэр сум-САА гэгдэх болсон.

Одоо 2500 км газар нутагтай, Мандал, Цогт-Өндөр, Баянгол, Үдлэг гэсэн 4 багтай, нийт 7000 гаруй хүн амтай. Батсүмбэр сумын хүн амын 1/3-ыг халх угсаатны бүлгээс бусад угсаатны бүлгүүд аж төрдөг гэсэн статистик тоо баримт бий.

Судлагдсан байдал: Богд хааны зарлигаар 1921 оны 11 дүгээр сарын 22-нд “Судар бичгийн хүрээлэн” –г байгуулсан тэр үеэс эхлэн эх түүх, хэл бичиг, утга зохиол, орон дэлхийгээ судлах ажлыг үүсгэн зохион байгуулжээ. 1924 оноос Түүхийн тасаг байгуулагдан Монголчуудын угсаа гарал, засаг захиргааны зохион байгуулалт, монгол хэл, шашин шүтлэг, зан заншил, Монгол нутагт буй археологийн дурсгалыг судлах, Монголын эртний мэргэдийн ном зохиол, судар бичгийг олж цуглуулах, монголын талаар гадаадын элчин, жуулчин, судлаач эдрэмтдийн туурвисан ном зохиолыг орчуулах, хэвлэж нийтийн хүртээл болгох зэрэг ажлуудыг төлөвлөгөөтэйгээр хийж байжээ. Судар бичгийн хүрээлэнгийн түүх судлалын салбарт гүн О. Жамъяан, түшмэл зайсан Ч.Бат-Очир, лам Чойждагва, Б.Дорж, Б.Буянчуулган, С.Шагж, Дандаа, Д.Нацагдорж зэргийн олон хүмүүс ажиллаж байв.¹

Ж.Цэвээн, Ө. Дорж, ахмад түүхч Хурц, Л.Санжаажамц, Ж.Самбуу, Я.Цэвэл, Г.Бадрах, Б.Батжаргал, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Х.Пэрлээ, Ч.Далай, Г.Сүхбаатар нарын бичсэн угсаатны зүйн холбогдол бүхий бүтээлүүдэд манай ард түмний эртнээс уламжлагдаж ирсэн хэв заншлын тухай өгүүлсэн байна.

Ж.Цэвээн монгол улсын түүх, соёл, угсаатны зүйн чиглэлээр олон арван бүтээл туурвисан бөгөөд “Монголын олон ястны гарал үүсэл, байдлын тухай” үнэт чухал бүтээл туурвисан юм.

Х.Пэрлээ “эртний судлалыг хөгжүүлэх үндэс суурийг тавьсан анхны археологич, түүхийн тулгар бичгүүдийг судалж, сурвалж судлалыг хөгжүүлэх хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан, монголын түүх бичлэгийн шавийг тавьсан, монголын эртний, дундад үеийг судалж түүхийн олон өгүүлэл бичиж шинэ санаа дэвшүүлсэн, монголын түүхийн сургалтанд томоохон хувь нэмэрэ оруулсан, Монгол оронд угсаатны зүй, түүхийн хавсрага ухаан-тамга судала, сурвалж судлал, орон нутаг судалал чиглэлээр анхны бүтээл туурвисан эрдэмтдийн нэг юм.

Академич Б.Ринчений удирдлага дор зохиогдсон “Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас” хамтын бүтээл нь анх удаагаа монголын олон овог, ястны

¹Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан. №4. ШУХ-ийн 1934 оны ажлын төлөвлөгөө, тайлан.

Музейн 2018 оны судалгаа

бүрэлдэхүүн, тархац болон тэдгээрийн эд өлөг, оюуны соёлын хэв маягийн талаас нь системчлэн газрын зурагт буулган үзүүлсэн. Монголын олон ястны овгийн бүрэлдэхүүнийг судлахад судлаачид энэ атласыг үндэс болгон, хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүн, эх сурвалж, тулгар бичгийг харьцуулан XIX-XX зууны зааг үеийн Монголын олон ястны угсаатны байдлыг тодотгоход чухал эх сурвалж болдог.

Манай орны угсааты зүйг XIX зууны дунд үеэс Оросын жуулчин, эрдэмтэн нарын тэмдэглэл, судлаачдын бүтээлүүдэд дурдагдсанаар угсаатны зүйн шинжлэх ухаанд их хувь нэмэрээ оруулсан. Оросын нэрт дорно дахиныг судлагч Н.Я.Бичуриний (Иакинф) нагиад сурвалж бичигт тулгуурлан бичсэн олон бүтээл, Оросын нэрт эрдэмтэн А.М.Позднеев, алдарт жуулчин Н.М. Пржевальский, Г.П.Потанин, М.В.Певцов, П.К.Козлов нарын замын тэмдэглэл болон нэрт жуулчин угсаатны зүйч Г.Е.Грум-Гржиймайло, Орос-Зөвлөлтийн эрдэмтэн Б.Я.Владимирцовын түүх-угсаатны зүйн бүтээлүүд нэн ач холбогдолтой. Дээрх шинжээчид хийгээд тэднийг залгамжлагч олон орны монголч эрдэмтдийн бүтээл нь орчин үеийн монголын угсаатны зүйн судалгааны сурвалж, сан хөмрөг болоод байна.

1950-иад оны сүүл үеэс эхлэн эдүгээг хүртэлх хугацаанд тус орны 21 аймгийн 200-аад суманд монголын бүх угсаатны бүлгүүдийн дунд хээрийн шинжилгээний ажлыг зохион байгуулж судалгааны арвин эх хэрэглэгдэхүүнийг хуримтлуулж судалгааны бааз суурийг бүрдүүлж чадсан байна.

1957-1962 оны хооронд хийсэн судалгааны үр дүнд С.Бадамхатан “Хөвсгөлийн цаатан ардын аж байдлын тойм” /1962/, “Хөвсгөлийн дархад ястан” /1965/ хэмээх бүтээлээ туурвисан. Мөн халх угсаатны зүйн судалгаанд 1968-1970 онд Боржгин халхчуудын дунд явуулсан угсаатны зүйн судалгааны үр нийтэлсэн “Боржгин халх” бүтээл юм. Энэ бүтээлд халхын нэгэ хэсэг “Боржгин халх” гэж өөрсдийгөө нэрлэдэг *Төв аймгийн Баянжаргалан*, Дорноговь аймгийн Сүмбэр /хуучнаар/, Даланжаргалан, Айраг, Иххэт, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан сумдын хүн ардын түүх, аж ахуй, эдийн болон оюуны соёлыг угсаатны зүйн цогцолбор аргачлалаар судалж Боржгин халхчуудын ахуй, соёлын өвөрмөц онцлогийг харуулсан байна.

Үүний нэг хэсэг бол Төв аймгийн нутагт Манжийн дарангуйллын үеэс эхлэн одоог хүртэл Баяд, Казак, Тува, Буриад, Барга угсаатны бүлэг нүүдэллэн ирсээр байгаа билээ. Төв аймгийн нутагт ямар угсаатны бүлэг, тэдний түүхэн занмалыг судлаж судалгаа, бүтээлдээ оруулсан байдаг.

Төв аймгийн угсаатны бүлгийн судалгааг гаргахад юун түрүүнд хүн амын тооллогод тулгуурлан гаргах учир анх хэдийнээс Монгол улс хүн амаа тоолж бүртгэлжүүлэх болсын, хэдэн удаа тооллого явуулсаныг тодруулая.

Монгол улс хүн амаа эрт үеэс бүртгэн, тоолж байсан баримт түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн боловч тооллогын хамарсан нунаг дэвсгэрийн хил хязгаар, он, хүн амын тоо нь нэлээд бүрхэг баримжаа өдий байдаг. Бидэнд байгаа баримтаар Хүннү гүрний үед хүн ам, мал тооллого явуулж байсан болон 1247 он буюу IV жарны 41 дэх улаагчин хонь жил “Монгол улс даяар хүн амын тооллого явуулав” гэсэн байдаг. Манай улс 1921 оны ардын хувьсгалын дараа хүн ам, хөрөнгө малын тоо бүртгэлийг 1922-1940 он хүртэл олон удаа (1922, 1929, 1933, 1935, 1937, 1939 онуудад) явуулж байсан бөгөөд тэдгээрийн үзүүлэлт нь маш өргөн хүрээтэй, өрх,

Музейн 2018 оны судалгаа

хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, малын тоо, малын хашаа саравч, гэрийн бүрээс, хадлангийн болон бусад ажлын багаж хэрэгсэл гэх мэт асуулыг багтааж байсан аж.

Хүн амын тооллого нь 200 гаруй жилийн тэртээгээс тодорхой давтамжтайгаар явагдаж, үр дүн нь албан ёсоор тэмдэглэгдэж иржээ. Гэхдээ Монгол улсад хүн амын тооллого ХХ зууныг хүртэл тогтмол явагдаж байгаагүй бөгөөд анхны тооллого 1918 онд явагдсан байна. Дараа нь 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000, 2010 онуудад ээлжит тооллогуудыг явуулсан юм. Мөн 2015 онд хүн ам, орон сууцны завсарын тооллогийг хийжээ. Улсын хэмжээнд 11 удаа тооллого явагдахад Төв аймаг ч хүн амын тооллогыг явуулж тайлан мэдээгээ ном маягаар хэвлүүлэн гаргаж гарын авлага болгосон байна.

Хүн амын тоо, тооллого явагдсан оноор:

Тооллого явагдсан он	Хүн ам (мян. хүн)			
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хүйсийн харьцаа
1956	29.1	26.1	55.2	111.5
1963	27.5	25.0	52.5	110.5
1969	33.1	30.5	63.6	108.5
1979	41.9	38.7	80.6	108.3
1989	51.1	49.0	100.1	104.3
2000	51.4	47.90	99.3	107.3
2010	44.1	40.1	84.2	109.1
2015	47	43	90	

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнгээр Төв аймагт суурин хүн ам 99268 хүн байсны 51.8% буюу 51374 нь эрэгтэй, 48.2% буюу 47894 нь эмэгтэйчүүд байна. 1979-1989 онд жилд 2.26 хувиар өсч байснаа 1989-2000 онд 0.05 хувь болж буурсан нь төрөлт буурч, хүн амын шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой. Мөн Төв аймагт 30 орчим ястан, үндэстний төлөөлөгч оршин суудаг. Нийт хүн амын 94.3 хувийг халх, 1.1 хувийг казах ястан эзэлж, дөрвөд, баяд, буриад, урианхай, тува зэрэг ястан 1989 оноос хойш Төв аймгийн хүн амд ястан, үндэстний эзлэх хувийн жинд өөрчлөлт оржээ. Энэ нь шилжих хөдөлгөөнэй холбоотой.

Үндэс угсаа	1989		2000	
	Хүн ам	хувь	Хүн ам	хувь
Нийт хүн ам	100088	100.0	99268	100.0
Халх	94773	94.6	93604	94.2
Казах	2167	2.2	1065	1.1
Буриад	590	0.6	856	0.9
Дөрвөд	727	0.7	770	0.8
Баяд	317	0.3	745	0.8
Урианхай	420	0.4	524	0.5
Тува	274	0.3	500	0.5
Захчин	160	0.2	202	0.2
Өөлд	61	0.1	171	0.2
Бусад	420	0.4	614	0.6

Музейн 2018 оны судалгаа

Гадаадын иргэн	179	0.2	217	0.2
----------------	-----	-----	-----	-----

2010 оны хүн ам, орон сууцны тооллогоор 43751 эрэгтэй, 40087 эмэгтэйчүүд тоологдсон байна. 2000-2010 оны хооронд хүн амын тоо жилд дунджаар 1.29 хувиар буурсан бөгөөд голлон нөлөөлсөн хүчин зүйл нь хүн амын ердийн өсөлтөөс давж гарсан хүн амын шилжилт хөдөлгөөн байв.


Үндэс, угсаа	2000 он		2010 он	
	Хүн ам	хувь	Хүн ам	хувь
Монгол улсын харьяат	99 051	100.0	83 653	100.0
Халх	93 604	94.5	77 472	92.6
Казах	1065	1.1	895	1.1
Дөрвөд	770	0.8	1202	1.4
Буриад	856	0.9	801	1.0
Баяд	745	0.8	1131	1.3
Урианхай	524	0.5	470	0.6
Захчин	202	0.2	316	0.4
Дархад	-	-	110	0.1
Торгууд	-	-	145	0.2
Өөлд	171	0.2	211	0.3
Тува	500	0.5	523	0.6
Бусад	614	0.6	377	0.4

Аймгийн хүн амын 92.6 хувийг Халхчууд эзэлж, өмнөх тооллогын үеийнхээс 1.90 пунктээр буурсан. Дөрвөдүүдийн эзлэх хувийн жин өнгөрсөн 10 гаруй жилд 0в6 пунктээр өсч, 1.4 хувийг эзэлж байгаа нь Халхчуудын дараа орлоо. Баяд, Казах, Тува, Урианхай, Өөлд, Торгууд 1.4-0.2 хувиар өссөн бол бусад угсаатны бүлгүүд 2000 оныхоос буурч, бусад угсаатнаас 25 хүн тоологдлоо.

Үндэсний статистикаас 2015 онд анх удаагаа хүн амын регистрт суурилсан бүртгэлийн аргаар хүн ам, орон сууцны завсрын тооллогыг зохион байгуулсан. Энэ тооллогод нийт 90421 хүн тооллогод хамрагдсанаас 46567 нь эрэгтэй, 43854 нь эмэгтэйчүүд байна.

2015 оны хүн ам, орон сууцны завсрын тооллогоор Төв аймгийн нутаг дэвсгэрт халх улсын хэмжээнд Казак 0.9% тооллогод хамрагдсан байна.

2017 онд сумдаас авсан тоон мэдээгээр Төв аймгийн Эрдэнэ, Батсүмбэр, Угтаалцайд, Заамар, Зуунмод сумдад илүү олон тархан суурьшиж байна. Төв аймгийн газрын зурагт Казак угсаатны тархалтыг тоон дүнгээр харуулав.



Казах үндэстэн Монголд нэгдсэн түүхээс: Казахстан улс нь казахуудын уугуул нутаг бөгөөд 1897 онд Казахууд хүн амын 73.9% нь байсан бол 1959 онд 30% хүртлээ буурч 1990-ээд оноос нэмэгдэн, 2009 оны байдлаар 65%-д хүрээд байгаа билээ. Казахстангаас гадна Орост (Астрахань, Волгоград, Самара, Оренбург, Челябинск, Курган, Тюмень, Омск, Новосибирск, Алтайн хязгаар) 1.3 сая, Хятадад (Шинжиан Уйгарын өөртөө засах орон болон Хөх нуур, Ганьсу мужид Казахын өөртөө засах Или /Или тарвагатай/ муж, Бар хөл, Мори, Аксайн өөртөө засах дүүрэг) 1.1 сая Казахууд оршин суудаг. Мөн Узбекистаны Каракалпакстан болон Ташкент орчим (бага жузийн Адай овгийнхон), Ираны хойд хэсэг Голестанд цөөн тоогоор амьдран суугаа билээ.

XVII зууны эхээр Монголын ойрад аймаг /Зүүнгар улс/ Казахын хаант улсад цөмрөн, умардаас Бухар, Хивийн феодалууд халдан түрэмгийлснээс Казахын хаант улс хүчин буурч, сарнин хуваагдаад нэг хэсэг нь Орос улсыг түшин дагаж, зарим нь Шинжааны Манж чин улсын харьяат болж 1780 оноос Абул Мамбет хааны харьяат казахууд Дорнод Туркестанд нутаглан Хар Эрчис, Алтайн газраар суух болжээ. Казахын хүн ард манж-хятадын болон феодалуудын дарлалд нэрвэгдэн, бэлчээр нутгаар хавчигдан ядуурсны дээр XIX зууны дунд үеэс Шинжаанд бослого үймээн дэгдэж түүний хөлд туйлдсаны улмаас 1864 оноос эхлэн

Музейн 2018 оны судалгаа

Алтайгаас Ховд руу Казах иргэд нүүдэллэн ирдэг байснаа 1867-1870 онд отог омгоороо шилжин нүүх хөдөлгөөн өрнөж нүүдэллэн Ховд нутагт бүрмөсөн шилжин нутаглах болсон².

Жантекей овгийн Бардамын үе залгамжлан захирагч Жуанган Шеруш, захирагч Сүкирбай нар Ховдын сайд Зоригт Жун Ванаар дамжуулан Монгол улсын харъяат болох хүсэлтээ Богд хаанд өргөсөн. Энэ сумын нийт өрх 313, эрс 325, эмэгтэйчүүд 406, хөвгүүд 255, охид 363, үүнээс нэг хошууны эр, эм, хүүхэд нийлж 1349 хүнтэй, мөн Шеруш нар ийнхүү байдалтай өргөдөл бичиж Монгол улсын харъяат болох өргөдлийг Богд хаанд өргөснөөр 1917 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн зарлигаар Казахуудыг Монголын харъяат болгосон байна³. Монгол улсад Казах үндэстэн одооноос 150 –аад жилийн өмнөөс ирж суурьшсан ба албан ёсоор Монгол улсын харъяат иргэд болж 100 гаруй жил болж байна. Казах үндэстэн олноор төвлөрсөн газар нь Монголын баруун хэсэгт байрлах Баян-Өлгий аймаг бөгөөд энэ аймгаас гадна Улаанбаатар хот, Налайх дүүрэг, Ховд, Төв, Дархан аймгуудад Казах үндэстэн хамгийн олон тоотойгоор амьдарч байна. 2015 оны Монгол улсын Хүн ам, Орон сууцны завсарын тооллогын мэдээгээр улсын хэмжээнд Казах үндэстний нийт хүн ам 114506 буюу Монгол улсын нийт хүн амын 3.9%-ийг эзэлж байна. Бүс нутгаар үзэхэд Төвийн бүсийн нийт хүн амын дотор Халх 92.8 хувь, Баянд 1.5 25.1 хувь, Дөрвөд 1.4 хувийг эзэлж байна. Казахуудын 75.5 хувь нь Баян-Өлгий аймагт амьдарч⁴ байна. Казахууд Баян-Өлгий Ховд, Сэлэнгэ, Төв аймгуудад болон Улаанбаатар хотын Налайх дүүргийн нийт хүн амын 30%-ийг эзэлж байгаа бөгөөд Төв аймгийн Эрдэнэ, Батсүмбэр, Заамар, Зуунмод, Угтаалцайдам зэрэг суманд Казахууд амьдарч, Төв аймгийн нийт хүн амын 0.9%, Төв аймгийн Эрдэнэ, Батсүмбэр, Угтаалцайдам сумдад голлон амьдарч байна.

Музейн судалгааны баг 2018 оны 3-р сарын 21-22-ны өдөр Казахын угсаа гарвал, уламжлалт соёлыг тодруулах зорилгоор Батсүмбэр сумыг зорин ирж, “Наурызын баяр” буюу нарын баярын соёл, уламжлал, үндэстний “Тулам булаалдах”, “Мөнгө шүүрэх”, “Кыз Куар” зурэг тэмцээнүүдийг сонирхон үзэж, суманд амьдарч байгаа казак үндэстний төлөөлөл болох Н.Жакей, А.Бүргэд, А.Сархад зэрэг ахмад настангуудтай уулзаж Наурызын баярын мэндчилгээ дэвшүүлэхийн ялдамд тэдэнтэй угсаа гарвал, уламжлалт ёс заншил, хувцас, хоол болон дээрх үндэсний тэмцээний талаар ярилцлага, судалгааг хийлээ.

Казахуудын уламжлалт соёл, ёс заншлаас

Монголын Казахууд нь Абага хэрэйд, Найман, Аргын, Уах, Төре, Хожа зэрэг овгоос бүрдэх бөгөөд Монголын нийт Казахуудын ихэнх хувийг Абага хэрэйдүүд эзэлдэг байна. Судлаачдын бүтээлээс үзэхэд хэрэйдүүд Ашамайлы керей, Абак керей хэмээх хоёр том бүлэгт хуваагдана. Абага хэрэйдүүд нь 12 овгоос бүрдэх бөгөөд эдгээр нь

1. Ители
2. Жадик
3. Жантекей
4. Шерууши
5. Каракас

²А.Минис, А.Сарай. БНМАУ-ын Баян-Өлгий аймгийн Казак ард түмний түүхээс. УБ., 1960. хуудас 8.

³Х.Силам, МАХН, Ардын төрөөс казак урианхайн дунд хэрэгжүүлсэн хувьсгалт ардчилсан өөрчлөлт. Диссертаци. Улсын нийтийн номын сан, 9/517.3, ДК.С-448. УБ., 1978. хуудас 47-50.

⁴Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. Хүн ам орон сууцны 2015 оны завсарын тооллого: Нэгдсэн дүн. УБ., 2016 он.

6. Молхы
7. Шыбарайгыр
8. Мэргэд
9. Жастабан
10. Сарбас
11. Көнсадак
12. Шимойын - нэр болно⁵

Судалгаанд хамрагдсан Төв аймгийн Казах иргэд нь Молхы болон Шерууши овогтой байна.

Шашин шүтлэг



Монгол дахь Казахууд нь уугуул орон нутгаас нүүж нийт Казах түмнээс тасран салж Шинжаанд суурьших болсон зуун дөч гаруй жилийн туршид нэгд: хил хязгаар Хятадын хилийн харуул хамгаалалтаас болж, хоёрт: Ислам шашны сүм хийд, сургууль, суурин төвөөс алслагдаж тасарсан зэрэг хүчин зүйл, шалтгааны улмаас шашин шүтлэгийн хувьд нэг ёсондоо тусгаарлагдан түгжигдмэл байдалд орсон нь тэдний амьдралд ислам шашин нэвтрэх үйл явцыг сааруулж удаашруулсан байна. Монголын Казахууд Шинжаанд нүүн ирж суурьших болсон хугацаанд шашны суурин байдалтай төв бүхий сүм хийд, сургууль соёлын газар барьж байгуулаагүй байсаар 19 зууны сүүлч үеэс эхэлж Ислам шашин идэвхжиж дэлгэрсэн ба сүм хийд, шашны сургууль баригдаж, Узбек, Тажик, Казахстангаас молла шашны зүтгэлтнүүд

Шинжаан дахь Казахуудын дунд ирж Ислам шашныг дэлгэрүүлэх, сүм хийд байгуулах, хүүхэд залуусыг шашны сургуульд хамруулан суралцуулах үйл ажиллагааг идэвхжүүлэх болжээ. Казахууд 19 зууны хоёрдугаар хагасаас шашин шүтлэг, хэл соёл ондоо Монголчуудын нутагт нүүн ирж суурьших болсон үед Ислам шашин шүтлэг хэл соёл ондоо Монголчуудаас өөрсдийгөө ялгах үндэсний онцлог, содон шинж, хүчин зүйл гэж үзэх болсон байна. Казахууд Монгол нутагт суурьшсанаас хойшхи үед анхны суурин сүмийг 1902 онд байгуулж, Ислам шашин тэдний аж төрөх ёс, шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, ёс заншлын нэгэн салшгүй хэсэг болж хэвших болжээ.⁶

Монголын Казахууд нь Исламын шашин шүтэхээс гадна уламжлалт бөө бөргөлийн шашныг шүтдэг бөгөөд энэ нь тэдний нүүдлийн мал аж ахуй



⁵ Монголын Казахын угсаатны зүй, -УБ., 2016, Х16-17

⁶ Монголын Казахын угсаатны зүй, -УБ., 2016, Х238-239

эрхлэх уламжлалт амьдарлын хэв маяг, байгаль дэлхийтэйгээ харьцах харьцаа зэргээс шалтгаалдаг байжээ. Казакуудын дунд 1940 оныг хүртэл бөө нар амьдарч байсан мэдээ бий. Казак бөө нар бусад угсаатны нэгэн адил өөрийн гэсэн эдлэл хэрэгсэл өвөрмөц онцлогтой зан үйл гүйцэтгэдэг байжээ. Тэдний өмсдөг хувцас нь ерөнхий хийц загвараараа бусад угсаатны бөөгийн хувцастай төстэй боловч, тэдний онгод, дуудлага зэрэгт ялгаатай зүйл олон байдаг. Казах бөө нарын элч онгод нь хүний нүдэнд үл үзэгдэх араатан-жигүүртэн төрхтэй бүргэд, чоно, шар шувуу, үнэг, буур, бух гэх мэт амьтад байдаг.⁷



Төв аймгийн Казакуудын уламжлалт шашин нь исламын шашин хэвээр байна. Гэвч бусад улсад дагаж мөрддөг исламын шашны дэг жаягийг өдөр тутмын амьдралдаа дагаж хэвшээгүй байна. Төв аймгийн Батсүмбэр суманд Исламын шашны сүм байгуулагдсан бөгөөд тэр сүмийн үйл ажиллагааг хөтлөн явуулдаг Имамтай (лам) болсон байна. Нутгийн ахмад настнууд өөрсдийн шашны тэмдэглэлт өдрүүдээр тухайн сүмдээ очиж мөргөл үйлддэг бөгөөд

энэ нь зөвхөн сайн дурын үндсэн дээр зохин байгуулагддаг. Мөн Казак иргэдийн байгаль орчноо хайрлах, байгалийн юмс үзэгдлийг өөр өөрийн гэсэн эзэн савдагтай гэсэн эртнээс нааш уламжилтж ирсэн үзэл нь одоо ч байсаар байна. Тухайлбал Хүүхэд залуусыг байгальтай хэрхэн зөв харьцах талаар амнаас ам дамжан хүмүүжүүлж иржээ⁸. Аливаа нэг булаг шандны ойрхон бие засахыг цээрлэнэ. Мөн булаг шанд, рашаан усны эхэнд цагаан даавуу уяна. Энэ нь уг булаг, ус эзэнтэй гэж үзэх бөгөөд, байгалиас хишиг хүртэсний хариуд хиргүй цагаан сэтгэлээр талархаж буйн илэрхийлэл хэмээн үздэг байна.

Наурызын баяр

Наурызын баярыг дэлхий дахинд Ойрхи Дорнод, Балканы хойг, Төв Ази, Кавказ зэрэг газар нутгийн 300 сая гаруй хүн өргөн тэмдэглэж өнгөрүүлдэг байна. 2010 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн 64 дэх хуралдаанаар Наурызыг олон улсын баяр болгон баталжээ. Улмаар ЮНЕСКО (НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, урлагийн байгууллага) Наурыз баярыг “Дэлхийн халдашгүй соёлын өв”-д бүртгэсэн.⁹ Наурыз бол шашны баяр бус, байгаль эхтэйгээ хүйн холбоотой хүн төрөлхтний баяр юм. Наурыз гэдэг нь перс гаралтай үг бөгөөд нау-шинэ, рыз-өдөр буюу “Шинэ өдөр” гэсэн утгатай¹⁰ ажээ. Өөрөөр хэлбэл өдөр шөнө тэнцэж, шинэ жил гарч байгааг бэлгэддэг. Казахууд нүүдэлчин ард түмэн учраас өвлийн хахир хатуу цагийг өнтэй давж, урин хавартай золгосны баяр болгон тэмдэглэдэг. Монгол улсын цагаан сартай зарим талаараа төстэй. Жил бүр тэмдэглэн ирсэн түүхтэй. Казахууд нарыг шүтдэг учраас 3-р сарын 22-ны өглөө эртлэн босож нарыг шинжин, тухайн жилийнхээ өнгийг хэлэлцдэг. Насанд хүрсэн казах эмэгтэйчүүд мандаж буй наранд ёсолж “амьдрал тэтгэж буй наран ээж минь” гэж

⁷ Монголын Казахын угсаатны зүй, -УБ., 2016, Х240

⁸ Батсүмбэр сумын иргэн А.Сархадтай хийсэн ярилцлагаас, 2018 он

⁹ Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц, -УБ., 2003,

¹⁰ Монгол үндэстний соёлын биет бус өвийн ховор хосгүй үнэт зүйлс, -УБ., 2012, Х11

залбирал үйлдээд хоорондоо золгож мэндэлснээр баяр эхэлдэг уламжлалтай¹¹. Мөн бүх хүн анхны нар харж, наранд сүү өргөж хүндэтгэнэ. Гэрийн эзэгтэй нар гэрийнхээ тооныг сүүгээр мялааж, хаалганыхаа босгыг таргаар мялаадаг ёс ч бий. Баярын үеэр бүгд үндэсний хувцсаа өмссөн байх агаад ахмад настан аксакалуудаа хүндэтгэн золгож, үдэж буй оныхоо ажил үйлс, ололт амжилтаа хүүрнэн дүгнэж, шинэ ондоо аз хийморь, арвин баялаг амжилттай байхыг ерөөн хүсдэг. Баяр угтаж эзэгтэй нар хэд хоногийн өмнөөс гэр орондоо их цэвэрлэгээ хийж, шинэ он буюу хаврын эхний өдрөө цэвэр цэмцгэр угтахыг эрмэлздэгээрээ цагаан сарын өмнө үйлддэг зан үйлтэй нэлээд төстэй юм. Уран эмэгтэйчүүд шинэ аравч, орны бүтээлэг хийн гэрээ гоёно. Залуу охид аав, ах нартаа зориулан шинэ тоорцгон малгай хийж, хээлж өгнө.

Батсүмбэр сумын иргэн А.Сархад гуай ярихдаа: *Наурызын баярыг хэзээнээс эхлэн тэмдэглэсэн талаар тогтоогдоогүй байгаа. Энэ хаврын баярын гол зорилго нь амьд амьтан*



ичээнээсээ гарч, амь орсныг бэлгэдэн хаврын баярыг тэмдэглэдэг. Нэг өдрийн өмнө бурхан бологсод, өвөг дээдэстэй цай өгнө гэдэг чинь бидний өвөг дээдсээс уламжлагдаад ирсэн. Яагаад гэвэл Казахын ард түмэн, казах үндэстэн эхлээд өвөг дээдсээ хүндлээд зөвхөн цай уухаар хязгаарлахгүй ном унших зэрэг өөрсдийн ёс жаягтай. Нэг ёсондоо өвөг дээдсээ, өнгөрсөн үеээ дээдлэх, хүндэлж байгаа юм.

Наурыз баярын үеэр ахан дүүс, хотол олонтойгоо золгох үед “Наурыз баярын мэнд! Муу бүхэн газрын гаваар орог, идээ будаа арвин байг, талаар дүүрэн малтай, гэрээр дүүрэн хүүхэдтэй болоорой!” хэмээн ерөөдөг¹² байна. Хоёр эрэгтэй хүн өөд өөдөөсөө харж зогсоод гараа атгалцан баруун зүүн хоёр талаараа цээжээрээ нийлж золгодог. Ийнхүү золгодог нь “Амь насны минь түшиг цээж минь, амьдралыг минь тэтгэгч хоёр гар минь эрүүл байг”¹³ гэсэн утгатай ажээ. Хоёр эмэгтэй тэврэлдэж золгоно. Эрэгтэй эмэгтэй хүмүүс гараа атгалцаж золгоно. Хоёр гараараа мэндчилэн цээжээрээ хүрч золгодог нь “амь насны минь түшиг цээж минь, амьдралыг тэтгэгч- хоёр гар минь эрүүл энх байг”¹⁴ гэсний бэлгэдэл гэж үзэх нь бий.



Хоол унд

¹¹ <https://mongoltoli.mn/history>

¹² <https://mongoltoli.mn/history>

¹³ Батсүмбэр сумын иргэн А.Сархадтай хийсэн ярилцлагаас, 2018 он

¹⁴ Батсүмбэр сумын иргэн А.Сархадтай хийсэн ярилцлагаас, 2018 он

Монголын Казакууд нь нүүдэлчдийн ард түмэн тул нүүдлийн мал аж ахуйн соёлын арга барилтай уялдан үүссэн өвөрмөц онцлогтой. Тухайлбал: Таван хошуу малын мах сүүгээр бүхий л хэрэгцээгээ хангаж ирсэн уламжлалтай. Хоол ундны тогтолцоо хэмээх ойлголтод юуны өмнө хоол, унд хийх гол бүтээгдэхүүн, хоол ундны үндсэн төрөл, тэдгээрийг хийж бэлтгэх арга, хоол унд идэж уухтай холбоотой ёс заншил хамаарна. Казакуудын уламжлалт хоол ундыг доорх хэдэн төрөлд ангилан үзэж болно. Үүнд: Цагаан идээн хоол, махан хоол, холимог хоолны төрлүүд, хоолны хольц буюу ааг амттан, цай ундаа, өдөр тутмын хоол унд, баяр ёслолын хоол унд гэсэн үндсэн төрлүүдэд хуваагддаг.¹⁵

Казахын хүмүүс болон тэднийд очсон зочид хоол идэхийн өмнө ба дараа нь гараа заавал угаадаг заншилтай¹⁶. Айл бүхэн услаг буюу сувлак тослог буюу маялак гэсэн усны ба тосны хоёр алчууртай байна. Харин ахмад хүмүүсийн ба зочны гарт усыг тэр гэрт байгаа хамгийн бага настай нь хийж үйлчилнэ. Энэ нь бохир гарын өвчнөөс урьдчилан сэргийлэхийн хамт хувцас хунарыг бохирдуулахаас сэргийлж байдаг урт насалж удаан жаргахын гол нөхцөл нь ариун цэврийг эрхэмлэх ёс юм¹⁷. Казах айлд зочилбол эхлээд танд аяганд цай хийж барина. Цай ууж дууссанаа илэрхийлэхийн тулд аяганы амсрыг таван хуруугаараа таглах эсвэл доош хөмөрч тавьдаг.¹⁸

Наурызын баярын хоол

Эмээ, гэрийн эзэгтэй нар өвлийн идэшнээс авч үлдсэн нарийн нандин, дээж хоол болох *жамбас-сүүж, жілік-чөмөгний яс, қазы- казы* –г зориуд үлдээн Наурыз баярын үеэр хэрэглэнэ. Настай эмэгтэйчүүд «Наурыз баяраар хэрэглэнэ» гэж гүзээтэй шар тос, ааруул, жент зэрэг цагаан идээг зориуд хадгална¹⁹.



Монголчууд цагаан сараар бууз банш иддэг бол казахууд шөл уудаг. Казахуудын хувьд 7-гийн тоо чухал бөгөөд баярын ширээнд мах, цагаан идээ, чихэр жимс гээд долоогоос доошгүй нэр төрлийн хоол унд байх учиртай. Шөл нь мах, гурил, өөх тос, үр тарианы төрөл, давс, сонгино, ус гэх мэт долоон төрлийн

хүнсээр амтлагдсан байх ба энэ нь амьдралын долоон өнгө болох баяр баясгалан, аз жаргал, амьдрах ухаан, эрүүл мэнд, эд баялаг, өсөлт хөгжилт, асран хамгааллыг илэрхийлдэг байна. Энэ баярын үеэр архи дарс огт хэрэглэдэггүй бөгөөд исламын ёслолд архи дарсыг бусад ариун идээний дэргэд байлгаж болдоггүй бузар зүйл гэж үздэг байна.

¹⁵ Монголын Казахын угсаатны зүй, -УБ., 2016, X122

¹⁶ Батсүмбэр сумын иргэн А.Сархадтай хийсэн ярилцлагаас, 2018 он

¹⁷ Нямбуу Х. Монголын угсаатан зүйн удииртгал, -УБ., 1992,

¹⁸ Батсүмбэр сумын иргэн Г.Шариптай хийсэн ярилцлагаас, 2018 он

¹⁹ Монгол үндэстний соёлын биет бус өвийн ховор хосгүй үнэт зүйлс, -УБ., 2012, X11

Наурызын баяраар аль болох олон айлд шөл уух тусам сайн хэмээн үзнэ. Ирсэн зочдод гэрийн ахмад хүнээр ерөөл хэлүүлэх ба сонсож буй хүмүүс алгаа хавсран нүүр рүүгээ харуулна. Ерөөл дууссаны дараа “тэр ерөөл бат оршиг” гэсэн утгатай “амин” гэж хэлээд хавсарсан хоёр алгаа нүүрэндээ хүргэх бөгөөд энэ нь ерөөлийг хүлээн авлаа гэсэн утгыг илэрхийлнэ. Наурызын баярын гол хоол болох Көжөө хэмээх адууны махаар хийсэн шөл бөгөөд энэ шөлөнд будаа, аарц хийнэ.

Гар урлал

Эсгий гэрийн модыг хус, хуш, хар мод, бургасаар дээвэр, туурга өрхийг эсгийгээр дотор чимэглэлийн зүйлсийг ноос, даавуу, ноосон утсаар ширэх, нэхэх, хатгах, томох, хувцас хунарыг даавуу болон арьсаар эмээл хазаар зэргийг мод, арьс шир, алт, мөнгө, төмрийн зүйлээр хослуулан тоноглож, гэрийн нөхцөлд гар аргаар урлан хийж, хэрэглэж иржээ. Казах гэрийн доторх чимэглэл ялангуяа үндэсний гоёлын хувцсыг хээ угалзгүйгээр төсөөлөхийн аргагүй. Хээ угалз нь маш олон төрөл байхаас гадна олон янзын өнгөөр, өнгө тохируулан чимэглэснээрээ өвөрмөц онцлогтой. Эдгээр хээ угалзыг судлаачид гурван бүлэг ангилан үздэг байна. Үүнд: 1. Ургамлын хэлбэртэй хээ угалз, 2. Амьтны хэлбэртэй хээ угалз, 3. Геометрийн хэлбэртэй гэж ерөнхийлөн ангилдаг байна.²⁰

Казахуудын дунд уламжлалт гар урлалын бараг бүх төрөл амжилттай хөгжжээ. Тухайлбал, алт, мөнгөний дарханчууд морины тахаас эхлээд гоёл чимэглэлийн зүйл, эмээл, хазаар, хутга, хайч зэрэг өдөр тутмын хэрэглээний зүйл, хөдөлмөрийн багаж, хэрэгсэл, гоёлын зүйл, морины тоног зэргийг урлан бүтээж байна. Казах эмэгтэйчүүд өнгө өнгийн ноосон утсаар гэрийн оосор, бүч, орны нүүрэвч, элдэв уут, савыг сүлжин хийдэг бөгөөд үүнийг "терме"²¹ гэдэг. Үүгээр гэр орныг гоёж чимэглэхэд өргөн ашиглана. Эдүгээ "терме" хийх уламжлал Баян-Өлгийн казахуудын дунд нэлээд уламжлагдан, жижиг үйлдвэр, гар урлалын түвшинд хөгжиж байгаач Төв аймгийн казахууд гар урлалын нэхмэл, хатгамалын урлалаа хийх хүн ховордсоор байгааг нутгийн иргэд ярьж байлаа.



²⁰ Монголын Казахын угсаатны зүй, -УБ., 2016, Х122

²¹ Монгол үндэстний соёлын биет бус өвийн ховор хосгүй үнэт зүйлс, -УБ., 2012, Х37

Музейн 2018 оны судалгаа

Судалгаанд хамрагдсан иргэд



Ургийн овог: Шеруш (Санарав)

Эцэгийн нэр: Адил гочоо

Өөрийн нэр: Сархад

Хүйс: Эр

Яс үндэс: Казах

Төрсөн он: 1955

Үндсэн захиргаа: Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, Алтай таван богд

Одоо оршин суугаа хаяг: Төв, Батсүмбэр сум, 1-р баг

Мэргэжил: Жолооч

Боловсрол: Бүрэн дунд

Одоо эрхэлж буй ажил: Тэтгэвэрт, мал малладаг

Хуучнаар аль хошуу:

Ам бул /эцэг эхээс/: 8 уулаа

Одоогийн ам бүл: 2

Шилжилт хөдөлгөөн:

Холбоо барих утасны дугаар: 88152292

Батсүмбэр сумын иргэн Г.Шарик /п/:



Ургийн овог: Молько /машан/

Эцэгийн нэр: Гаип шарика

Өөрийн нэр: Шарип /к/

Хүйс: Эм

Яс үндэс: Казах

Төрсөн он: 1955.02.10

Үндсэн захиргаа: Ховд аймгийн Ховд сум

Одоо оршин суугаа хаяг: Төв, Батсүмбэр сум, 1-р баг

Мэргэжил: Барилгачин

Боловсрол: Бүрэн дунд

Одоо эрхэлж буй ажил: Тэтгэвэрт, мал малладаг

Хуучнаар аль хошуу:

Ам бул /эцэг эхээс/: 8 уулаа

Одоогийн ам бүл: 2

Шилжилт хөдөлгөөн: 1957 онд аав ээжтэйгээ ирсэн. Аав Гаип нь мод бэлтгэх, САА-д цахилгаанчин, ээж нь гэрт

Батсүмбэр сумын иргэн : Н.Жакет

Ургийн овог: Шеруш

Музейн 2018 оны судалгаа



Эцэгийн нэр: Навыхан

Өөрийн нэр: Жакет

Хүйс: Эр

Яс үндэс: Казах

Төрсөн он: 1952

Үндсэн захиргаа: Баян-Өлгий аймаг, Ногооннуур сум, аав Навыхан нь 1915 онд төрсөн. Намайг 3 настай байхад

Одоо оршин суугаа хаяг: Төв, Батсүмбэр сум, 2-р баг

Мэргэжил: Жолооч /Атарт/

Боловсрол: Бүрэн дунд

Одоо эрхэлж буй ажил: Тэтгэвэрт, мал малладаг

Хуучнаар аль хошуу:

Ам бул /эцэг эхээс/:

Одоогийн ам бүл: 8 /6 хүүхэдтэй/

Шилжилт хөдөлгөөн: 1956 онд Батсүмбэрт шилжиж ирсэн

Холбоо барих утасны дугаар: 99528144, 88528144

Батсүмбэр сумын иргэн: М. Касира

Ургийн овог: Молко

Эцэгийн нэр: Машан

Өөрийн нэр: Касира

Хүйс: Эм

Яс үндэс: Казах

Төрсөн он: 1956

Үндсэн захиргаа: Ховд аймаг, Ховд сум,

Одоо оршин суугаа хаяг: Төв, Батсүмбэр сум, 2-р баг

Мэргэжил: барилгачин, малчин

Боловсрол: Бүрэн дунд

Одоо эрхэлж буй ажил: Тэтгэвэрт, мал малладаг

Хуучнаар аль хошуу:

Ам бул /эцэг эхээс/:

Одоогийн ам бүл: 8 /6 хүүхэдтэй/

Шилжилт хөдөлгөөн: 1957 онд Батсүмбэрт шилжиж ирсэн

Холбоо барих утасны дугаар: 99528144, 88528144

